



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Гадаадад төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” 2010 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 391 дүгээр тушаалын Пэрэнлэйлхагвын **Бүнчинжавтай** холбогдох хэсгийн “Австрали Улсын Нью Саут Уэйлсийн ИС Мельбурний их сургуулийн магистрантурт Байгаль орчны нөхөн сэргээлт чиглэлээр” гэснийг “АНУ-ын Виржиниягийн их сургуулийн магистрантурт Байгаль орчны бизнес удирдлагын чиглэлээр”, 2010 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 394 дүгээр тушаалын Сосорбарамын **Наранхүүтэй** холбогдох хэсгийн “Мельбурний их сургуулийн магистрантурт Олон улсын эрх зүйн чиглэлээр” гэснийг “Сэнтрал Куинсландын их сургуулийн магистрантурт Мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр”, 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 475 дүгээр тушаалын Хүрэлбаасангийн **Энхгэрэлтэй** холбогдох хэсгийн “Гадаад харилцааны яамны захиалгаар” гэснийг “Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Е.ОТГОНБАЯР

	ХУУЛБАР ҮНЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА <i>М.ЦЭДЭВСҮРЭН</i> 2011 оны 3. сарын 28 өдөр
---	--